



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын филарманийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 15 нэрийн, нийт 8,044,500.00 (найман сая дөчин дөрвөн мянга таван зуу) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Цэвэгдорж, Улсын филарманийн захирал С.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн
34 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ФИЛАРМОННИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад (дахин үнэлсэн) орсон огноо	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг
Тавилга, аж ахуйн эд хогшил							
1	Конторын сандал	ш	1	2013-01-01	41,800	41,800.00	0
2	Конторын сандал	ш	2	2013-01-01	83,600	167,200.00	0
3	Конторын сандал	ш	1	2013-01-01	41,800	41,800.00	0
4	Конторын сандал	ш	1	2013-01-01	41,800	41,800.00	0
5	Конторын сандал	ш	1	2013-01-01	41,800	41,800.00	0
6	Тек төрийн сан	ш	1	2014-12-30	2,145,000	2,145,000.00	0
7	Конторын ширээ	ш	1	2013-01-01	212,300	212,300.00	0
8	Конторын ширээ	ш	1	2013-01-01	212,300	212,300.00	0
9	Конторын ширээ	ш	1	2013-01-01	212,300	212,300.00	0
10	Конторын ширээ	ш	1	2013-01-01	212,300	212,300.00	0
11	Конторын ширээ	ш	2	2013-01-01	212,300	424,600.00	0
12	Жижиг ширээ	ш	1	2014-12-30	71,500	71,500.00	0
	Тавилга, аж ахуйн эд хогшлын дүн		14			3,824,700.00	0
Машин, тоног төхөөрөмж							
13	Камер	ш	1	2019-09-27	2,400,000	2,400,000.00	0
14	Камер /зааланд суурилсан/	ш	1	2019-09-27	960,000	960,000.00	0
15	Принтер MFP-M130A	ш	2	2018-12-25	429,900	859,800.00	0
	Машин, тоног төхөөрөмжийн дүн		4			4,219,800.00	0
	Нийт дүн		18			8,044,500.00 (найман сая дөчин дөрвөн мянга таван зуу)	0